



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨХК-ИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/54/СТА-ТӨҮГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2018 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан	3
2.1. Оршил.....	4
3. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
4.1. Үйл ажиллагаа:.....	5
5. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..	6
6. Материаллаг байдал	7
7. Дотоод хяналт	7
8. Зорилтод түвшингийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
9. Шилэн дансны мэдээлэл.....	8
10. Олж тогтоосон эрсдэлүүд, түүний үр дагавар.....	9
11. Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	9
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	12
14. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	12
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
16. Зөрчилгүй санал дүгнэлт	13
17. Менежментийн захидал	14
18. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, зорилтод түвшингийн гүйцэтгэл.....	20



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН
СТАНЦ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ С.БЯМБААХҮҮ ТАНАА

2018.03.15 № 06/755
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichin_Khuregi\Yawsan_Bichin\2018\03\15\06\001.docx

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

071392


Үүрэг, хариуцлага

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын хийж тайлан дүгнэлтийг ТУЗ, гүйцэтгэх захирал С.Бямбаахүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг тодорхойлсон болно.

3. АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд /САГ-2018/54/СТА-ТӨҮГ/-т санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/-тай нийцүүлж материаллаг алдаагүй нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан нь дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 25-ны өдөр “Си Эс Ай Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Си Эс Ай Аудит” ХХК нь аудитыг 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдөр хүртэл гүйцэтгэхээр төлөвлөн тайлан дүгнэлтийг баталгаажуулан 2018 оны 03 сарын 15-ны өдөр Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захиралд гардуулна.

4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь **“Найдвартай эрчим хүч Шинэ технологи Өөдрөг амьдрал”** гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн цахилгааны эрчим хүч, дулааны эрчим хүч, үйлдвэрийн технологийн хэрэгцээний уур үйлдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь Монгол Улсын “Компанийн тухай”, “Эрчим хүчний тухай”, “Цахилгаан дулааны эрчим хүч, нүүрсний төлбөрийн тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Галын аюулгүй байдлын тухай”, “Гамшгаас хамгаалах тухай”, “Усны тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай”, “Эрчим хүч хэмнэлтийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Шилэн дансны тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай”, “ХХОАТатварын тухай”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай”, “Нийгмийн даатгалын тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэж байна.

Тайлант хугацаанд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

4.1. Үйл ажиллагаа:

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь 1961 онд ТС-35-39 маркийн ул ширэмтэй 3 зуух, АК-6 маркийн 2 турбингенератортай 12 мвт-ын суурилагдсан хүчин чадалтайгаар баригдаж, толгойтын цахилгаан станц нэртэйгээр ашиглалтанд орсон ба 1969 онд өргөтгөл хийж өнөөдрийн байдлаар тус станц нь 24 мвт цахилгаан эрчим хүч, 55 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэж, жилд 130 сая квт ЦЭХ, 190 мянган Гкал дулааны эрчим хүч түгээх хүчин чадалтайгаар ажиллаж байна.

Үйлдвэрлэлийн хүчин чадал

- Цахилгаанаар 142,46*10 квт/цаг
- Халуун усаар өгөх дулаан – 158,83 Гкал/жил
- Уураар өгөх дулаан (технологийн уур) – 278,17 Гкал/жил

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь 1961 онд ТС-35-39 маркийн ул ширэмтэй 3 зуух, АК-6 маркийн 2 турбингенератортай 12 мвт –ын суурилагдсан хүчин чадалтайгаар баригдаж, Толгойтын цахилгаан станц

нэртэйгээр ашиглалтанд орсон ба 1969 онд өргөтгөл хийж өнөөдрийн байдлаар тус станц нь БКЗ-75-39 фб маркийн 2 зуух, ТС-35-39 маркийн 2 зуух, DHF-35 маркын 1 зуух, АК-6, ПТ-12-35/10, N6-3,43 маркийн 3 турбингенератортай 24 мвт-ын суурилагдсан хүчин чадалтайгаар ажиллаж байна.

Цахилгаан эрчим хүчний суурилагдсан хүчин чадал ашиглалт 77.0 гаруй хувьтай, усаар түгээх дулааны хүчин чадал ашиглалт 70.0 гаруй хувьтай байна.

Дэд бүтэц

- Цахилгаан, Дулаан - өөрөөсөө
- Ахуйн ус хангамж - нийслэлийн төвлөрсөн системээс
- Үйлдвэрийн ус хангамж - өөрөөсөө
- Холбоо - МЦХ ХК болон үүрэн телефоны операторууд
- Зам - нийслэлийн төв зам, өөрийн дотоод замыг ашиглана.
- Тээвэр - “Улаанбаатар” төмөр замын толгойт өртөөнөөс, болон өөрийн авто аж ахуйг ашиглана.
- Бохир ус - ахуйн бохир усыг нийслэлийн ариутгах татуургын системд, үйлдвэрлэлийн хаягдал усыг үнсэн санд нийлүүлнэ.

Боловсон хүчин:

Тус компани нь 2017 оны байдлаар нийт 297 ажиллагсадтайгаас удирдлага 3, ИТА 74, ажилчид 220 байна.

Алба хэлтэс:

Тус станц нь одоогоор Түлш дамжуулах, Турбин – Хими, Зуух, Цах-ДХХА - ийн 4 цех, Инженерийн бодлого төлөвлөлт техник хангамжийн 1 алба, Хяналтын, Захиргаа аж ахуйн, Санхүү бүртгэлийн 3 хэлтэстэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсын засгийн газрын 2001 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 164 дүгээр тогтоолоор 100 хувийн төрийн өмчит хувьцаат компани болгон зохион байгуулагдсан байна.

Монгол Улсын “Эрчим хүчний тухай” хуулийн дагуу 3 төрлийн тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Тайлант онд хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

5. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын Олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт 1000-1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна тус

байгууллагын удирдлагаас тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.
/ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансыг түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 19-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн UNICUS програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь 2014 онд хийсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг бөгөөд 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Сангийн сайдын 249 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, “Аж ахуй нэгжийн нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт”, Санхүү, эдийн засгийн сайдын 2000 оны 116 тоот тушаал хүчингүй болсон зэрэг өөрчлөлтүүдийг хийгээгүй хүчингүй дансны нэгдсэн жагсаалтыг мөрдөж байна.

6. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үеийн материаллаг байдлын суурь түвшинг 2016 оны 12 дугаар сарын 31-ний орлогын тайланг үндэслэн нийт 19,409.2 сая төгрөгийн орлогын нэг хувь буюу 194.1 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 21,127.7 сая төгрөгийн нэг хувь буюу 211.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Нийт орлогын дүнгээс материаллаг түвшинг сонгож авсан шалтгаан нь тухайн компанийн тайлант үеийн үйл ажиллагаанд нөлөөлж чадахуйц суурь үзүүлэлт гэж үзсэн аудитын явцад төлөвлөгөөнд өөрчлөлт ороогүй болно.
/ТАБ-СТА-В-1/

7. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Тус байгууллагад орон тооны дотоод аудитор ажиллаж байгаа бөгөөд 2017 онд дараах ажлыг хийж дүгнэлт өгч ирсэн байна. Үүнд:

1. Компанийн зорилтод түвшин, их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө компанийн зорилгод нийцэж бодитой үнэн зөв үр ашигтай хийгдсэн эсэх.
2. Хууль тогтоол, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангаж байгаа байдалд аудит хийх.
3. Санхүүгийн тайлангийн аудит
4. Авлага, өглөгийн бүртгэлд аудит хийх
5. Үндсэн хөрөнгийн бүртгэлд аудит хийх
6. Цалин хөлс болон мөнгөн хөрөнгийн бүртгэлд аудит хийх
7. Компанийн хэмжээнд хийгдсэн их засвар, урсгал засварын ажил, ТЗБАХ-ийн гүйцэтгэл тайлан тэнцэлд хэрхэн тусгагдсан хяналт шалгалт хийх.
8. Гадаад, дотоод гэрээ хэлэлцээрийн биелэлт
9. Төрийн өмчийн хөрөнгийг түрээсээр ашиглуулсан байдал, үр дүнд шалгалт хийж зөвлөмж өгч ажиллаж ирсэн байна.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

8. Зорилтод түвшиний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны батлагдсан зорилтот түвшинг, гүйцэтгэлтэй харьцуулж үзвэл:

Борловсруулсан цахилгаан эрчим хүч 151.6 сая квт/ц үйлдвэрлэхээс 151.2 сая. квт/ц буюу 99.7%-иар төлөвлөгөөг биелүүлсэн.

ДХ ЦЭХ 22.1 сая квт/ц үйлдвэрлэхээс 20.4 сая. квт/ц үйлдвэрлэж төлөвлөгөөг 92.4%- иар, цахилгаан 129.5 квт/ц үйлдвэрлэхээс 130.7 сая квт/ц буюу 101%-иар, дулаан 193.0 мян Гкал үйлдвэрлэхээс 195.6 мянган Гкал буюу 101.4%-иар үйлдвэрлэлийн төлөвлөгөөг биелүүлж ажилласан байна.

2017 онд ЦЭХ-ний борлуулалт 17,516.2 сая, ДЭХ-ний орлого 2,209.3 сая, үйл ажиллагааны бус орлого 170.4 сая буюу нийт орлого 19,895.9 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр ЦЭХ-ний орлого 18,571.3 сая, ДЭХ-ний орлого 2,292.1 сая үйл ажиллагааны бус орлого 170.4 сая буюу нийт 21,127.7 сая төгрөгийн борлуулалт хийж орлогын төлөвлөгөөг 1,231.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн.

Зардал 21,127.6 сая төгрөг төлөвлөснөөс 21,033.1 сая төгрөгийн зардлын гүйцэтгэл гарч 94.5 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

9. Шилэн дансны мэдээлэл

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь шилэн дансны тухай хуулийн дагуу улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор удирдлагын шийдвэр, үйл ажиллагааг ил тод нээлттэй, ойлгомжтой байхад нийцүүлэн shilendans.gov.mn сайтад батлагдсан маягт, хавсралтуудын дагуу Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн

цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус үүргийн хүрээнд шилэн дансны нэгдсэн сайтад мэдээллээ тогтмол байршуулсан байна.

10. Олж тогтоосон эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөлтийн дагуу 19 эрсдэлийг тогтоож батламж мэдэгдлүүдийн хүрээнд нийт данс бүрээр 19 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

11. Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах алдаа, зөрчил илэрснийг доорх байдлаар шийдвэрлэсэн болно.

1. ТӨБЗГ-т 2015 оны ногдол ашиг 33.8 сая, 2016 онд 142.0 сая, нийт 175.8 сая төгрөгийн ногдол ашиг олгосон боловч ногдол ашгийн татварын 10 хувийг суутгаж аваагүй, ногдол ашгийн татварыг төлөхөөр тайлагнаагүй нь Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9.1. “Албан татвар төлөгчийн хөрөнгийн дараахь орлогод албан татвар ногдоно”.. 9.1.3. ногдол ашгийн орлого гэж .. 6.3.-д “дараахь орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо албан татвар ногдуулах тухайн орлого тус бүрийн нийт дүнгээр тооцно”..16.3.1. “ногдол ашгийн орлого” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:


Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 17.2. дугаар зүйлийн 17.2.1. “ногдол ашгийн орлогод 10 хувиар”... гэсэн заалтыг үндэслэн олгосон ногдол ашгаас 17.6 сая төгрөгийн ногдол ашгийн татварыг төлөхөөр тооцон данс бүртгэлд бүртгэх, төлөөгүй ногдол ашгийн татварыг нөхөн төлүүлэхээр акт тавих.

2. Худалдсан 75.0 сая төгрөгийн нүүрсний өртгийг үйл ажиллагааны зардал дансанд бүртгэсэн нь үйл ажиллагааны зардлыг өсгөж өртөгийг бууруулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл. Хөрөнгө, өр төлбөрийг үнэлэх, бүртгэх ... 9.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Сангийн сайдын 2014 оны 249-р тушаалын 1 дүгээр хавсралт “аж ахуй нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-ыг дагаж мөрдөх, СТОУС-ын дагуу борлуулсан нүүрсийг бараа материалын өртөг дансанд бичилт хийх зөвлөмж өгөв.

3. 2011-2017 он хүртэл санхүүгийн тайланд 46.4 сая төгрөгийн урьдчилж гарсан зардал бүртгэлтэй байгааг шалгаж үзэхэд 2011 онд ЭБЭХЯ-ны төрийн нарийн бичгийн даргын №70 тоот



түшиглэн хагас коксжуулсан утаагүй цэвэр түлш үйлдвэрлэх цогцолбор байгуулах, төслийн талбарт хяналт тавих ажлын хэсгийг томилж, төслийн хяналтын зардалд 298.0 сая төгрөгийн санхүүжилтийг баталсанаас ЭБЭХЯ-наас 2011 оны 12 дугаар сард 104.6 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж санхүүжилт орж ирээгүйгээс урьдчилж гарсан төслийн хяналтын 46.4 сая төгрөгийн зардлыг байгууллага санхүүжүүлэн төсөл хяналтын урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн бөгөөд 2015 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн Эрчим хүчний яам в/111 албан бичигт /Уг төсөл арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлтэй уялдуулан улсын төсвөөс санхүүжүүлж байсан ба хийгдсэн санхүүжилтэд ногдох техник хяналтын зардлыг танай компанид өгч байсан байна. Эрчим хүчний яам байгуулагдсанаас /2012 оны 08 дугаар сараас/ хойш уг төсөл арга хэмжээнд санхүүжилт хийгээгүй тул техник хяналтын зардлыг танай компанид өгөөгүй болно. Энэхүү төсөл арга хэмжээний санхүүжилт 2014 оноос хойш улсын төсөвт тусгаагүй тул үлдэгдэл техник хяналтын зардал 46.4 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэх боломжгүй/ гэжээ. Тайлант жилд хаалгүй одоог хүртэл эхний үлдэгдлээр тайлагнаж байгаа урьдчилж гарсан төслийн хяналтын зардал 46.4 сая төгрөг нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-ыг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл. Хөрөнгө, өр төлбөрийг үнэлэх, бүртгэх...8.7-д “Орлого, зарлагыг залруулгын гүйлгээгээр тохируулж бүртгэх бөгөөд түүнийг орлого, зарлагад тооцохгүй”...гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

2012 онд урьдчилж гарсан хяналтын зардлыг жилийн эцэст хааж өгөөгүйгээс үүссэн 46.4 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлыг холбогдох баримтыг үндэслэн өмнөх үеийн хуримтлагдсан үр дүн дансанд залруулах.

4. 2010 оны санхүүгийн тайланд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын зураг төсөв хийлгэсэн 26.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын зардалд капиталжуулж аваагүйгээс одоог хүртэл данс бүртгэлд урьдчилж гарсан зардлаар бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.”Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, 15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна”, 8.7-д “Орлого, зарлагыг залруулгын гүйлгээгээр тохируулж бүртгэх бөгөөд түүнийг орлого, зарлагад тооцохгүй”...гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын зураг төсөв хийлгэсэн 26.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын зардалд капиталжуулж аваагүйгээс одоог хүртэл данс бүртгэлд урьдчилж гарсан зардлаар бүртгэлтэй байгаа урьдчилж гарсан зардлыг залруулах.

1. Эрчим хүчний салбарын 2017-2018 оны хамт/тариф/-ын хэлэлцээрт эрчим хүчний компаниудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /ХХДХ/-нээс тооцох итгэлцүүрийг тогтоож өгсөн. “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн мөрдөгдөж буй уг итгэлцүүрийг цагийн тарифт цалингийн 2 дугаар зэргээс эхлэн мөрдөгдөж байгаа ба ажилд ороод жинхлэх шалгалт өгсөн ажилтнууд нь цаг зэргийн тарифт цалингийн 3 дугаар зэргээс эхлэн цалинждаг.

Тус компанийн ҮЭ-ийн хорооноос дээрх итгэлцүүрийг мөрдөж ажиллаагүй тухай Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /МХЕГ/-т ХХДХ-г хянуулахаар гомдол гаргасны дагуу Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагч шалгаж, цалингийн зөрүүг нөхөн олгох, цаашид цаг зэргийн тарифт цалинг Салбарын хамтын хэлэлцээр, хамтын гэрээнд тусгагдсан итгэлцүүрээс тооцож цалинг нэмэгдүүлэхэд санхүүгийн эх үүсвэргүй бөгөөд компанийн эдийн засгийн чадавхид нөлөөлөхөөр байна.

2. Салбарын хамтын хэлэлцээрт ХХДХ-нээс тооцох итгэлцүүрийг хэвийн, хэвийн бус гэж зааж үндсэн цалингийн суурь болгож байгаа нь Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-д заасан үндсэн цалин, нэмэгдэл хөлс гэсэн ойлголтуудтай зөрчилдөж байна.

13. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэхээр анхаарал татсан асуудал нь цалин тогтоож байгаа хууль эрх зүйн актыг нарийвчлан шалгах, давхцсан журам, хэлэлцээрийн давхардсан зөрчилдөж байгаа заалтыг судлах цаашид цалингийн мөрдөх журмын тодорхой болгох асуудалд анхаарал хандуулах.

14. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 208.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 17.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 191.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Эдгээр зөрчлийг асуудлын бүртгэлд нэгтгэж, баталгаажуулсан болно.

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	5	191.20	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	17.58	
3	Албан шаардлага өгсөн	-	-	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	-	-	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	-	-	
	Дүн	6	208.78	

15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2016 оны санхүүгийн тайланд “Дунд манхайдай Аудит” ХХК аудит хийж 4 зөвлөмж өгсөнөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж 1 зөвлөмжийг 80% хэрэгжүүлсэн нь “Аморе Интернешнл” ХХК-иас авах авлагын үлдэгдэл 20.2 сая төгрөг 2018 онд барагдуулахаар ажиллаж байна.

16. Зөрчилгүй санал дүгнэлт

Дээр дурьдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 24 хуудас, хавсралтууд хуудас, байгууллагын санал .. хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ


ХЯНАСАН:

“СИ ЭС АЙ АУДИТ” ХХК-ИЙН

ПАРТНЕР:

АХЛАХ АУДИТОР:

БЭЛТГЭСЭН: АУДИТОР:



**“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН****МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

“СИ ЭС АЙ АУДИТ” ХХК
Хаяг: УБ хот Чингэлтэй дүүрэг
4-р хороо Цэцээ гүн төв 206 тоот
Утас: 70001981, 99096584
Зөвлөх үйлчилгээ:
Утас: 19001981

Тэргүүлэх ач холбогдол № 1

Асуудал 1 Санхүүгийн тайлагнал.....
Асуудал 2 Бараа материал.....
Асуудал 3 Үндсэн хөрөнгө
Асуудал 4 Тайлант үеийн үеийн үр дүн

Тэргүүлэх ач холбогдол № 2

17. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын Олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

1. Санхүүгийн тайлагнал

Тэргүүлэх ач холбогдол №1

Ажиглалт

2010 онд гарсан урьдчилж гарсан зардлыг ДҮ, өртөгт хаагаагүй нягтлан бодох бүртгэлийн буруу бичилтээс болж үүссэн 72.4 сая төгрөг одоог хүртэл үлдэгдлээр бичигдэж ирсэн байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-т “Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо мэдээнд үндэслэх”, 20.2.6-д...“Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”...гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна

Эрсдэлүүд

Хөрөнгө буруу илэрхийлэгдэх.

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.1. Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна гэсэний дагуу санхүүгийн тайланд дээрхи 72.4 сая төгрөгийн залруулга хийж тайлангийн үлдэгдлийг үнэн зөв илэрхийлэх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор ҮАГ-т ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

2. Бараа материал

Тэргүүлэх ач холбогдол №1

Ажиглалт

Худалдсан 75.0 сая төгрөгийн нүүрсний өртгийг үйл ажиллагааны зардалд бүртгэсэнээс үйл ажиллагааны зардал өсгөж өртөгийг бууруулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл. “Хөрөнгө, өр төлбөрийг үнэлэх, бүртгэх”, 9.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”.. гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Өртгийн данс буурч, үйл ажиллагааны зардал өсөх.

Өртөг зардал буруу илэрхийлэгдэх.
Зардалд тавих хяналт алдагдах.

Зөвлөмж

Сангийн сайдын 2014 оны 249-р тушаалын 1 дүгээр хавсралт “аж ахуй нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-ыг дагаж мөрдөх, СТОУС-ын дагуу борлуулсан нүүрсийг бараа материалын өртөг дансанд бичилт хийх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор ҮАГ-т ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

3. Үндсэн хөрөнгө

Тэргүүлэх ач холбогдол №1

Ажиглалт

ТУЗ-ын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар тогтоолд компанийн ажилтан Ц.Батбаатар, Д.Пүрэв нарт 2005 онд орон сууцны дэмжлэг үзүүлэх зорилгоор олгосон тус бүр нь 11.5 сая төгрөгийн нэг удаагийн тусламж нийт 23.0 сая төгрөгийг барилга байгууламж дансанд 2 орон сууц нэрээр бүртгэсэн орон сууц нь бүртгэлийн гэрчилгээ хувь хүмүүсийн нэр дээр байгаа, орон сууцны нөхцөл сайжруулахаар өгсөн мөнгөн тусламжийг хөрөнгөөр бүртгэсэн нягтлан бодох бүртгэлийн алдааг засаж залруулахыг гүйцэтгэх захирал С.Бямбаахүүд үүрэг болгосон боловч энэ даалгавар биелэгдээгүй нь СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.1. Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна., 15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна... гэсэн” заалтыг зөрчсөн байна.

Зөвлөмж

Тус компанийн ажилтан Ц.Батбаатар, Д.Пүрэв нарт 2005 онд орон сууцны дэмжлэг үзүүлэх зорилгоор олгосон 23.0 сая төгрөгийг тухайн үеийн бүртгэлийн буруу бичилтээс үндсэн хөрөнгөнд бүртгэсэнийг зохих баримтыг үндэслэн залруулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор УАГ-т ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.
Үндсэн хөрөнгө үндэслэлгүй нэмэгдэх.
Үндсэн хөрөнгө эзэмшилд байхгүй байх
Санхүүгийн тайлангийн ОБ, ИБ, ҮЗ, ЭҮ,ТИ гэсэн батламж мэдэгдлийг зөрчиж байна.

Төсвийн захирагчийн хариу

Зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

4. Тайлант үеийн үр дүн

Тэргүүлэх ач холбогдол №1

Ажиглалт

2015 онд 33.8 сая төгрөгийн 2016 онд 142.0 сая төгрөгийн ногдол ашгийг тус тус олгосон боловч тухайн олгосон ногдол ашгийн 10 хувийн татвар 17.6 сая төгрөгийг суутган аваагүй, ногдол ашгийн өглөг дансанд бичилт хийгээгүй байна.

Зөвлөмж

Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 17.2 дугаар зүйлийн 17.2.1. ногдол ашгийн орлогод 10 хувиар... гэсэн заалтыг үндэслэн олгосон ногдол ашгийн татварыг төлөхөөр тооцон данс бүртгэлд бүртгэх. Цаашид дансны бичилтийг зөв хийх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор УАГ-т ирүүлэх

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.
ААНОАТ-ын тухай хуулийн дагуу ногдол ашгаас татвар тооцон татварын өглөг үүсгээгүй тайлагнаагүйгээс торгууль алданги тооцуулах эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу

Зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

“СИ ЭС АЙ АУДИТ” ХХК-ИЙН
ПАРТНЕР:
АХЛАХ АУДИТОР:
БЭЛТГЭСЭН: АУДИТОР:



М.СЭВЖИДМАА
С.СОДНОМЦЭРЭН
Д.ЧУЛУУНБАТ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

18. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

/Төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгө	326,238,551.52	195,595,940.20
1.1.2	Дансны авлага	445,055,032.01	303,543,061.72
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага	61,120,036.98	22,431,056.13
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	851,245,367.89	972,950,806.06
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	87,697,730.99	200,821,104.24
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,771,356,719.39	1,695,341,968.35
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	18,253,556,902.54	35,412,286,281.94
1.2.2	Биет бус хөрөнгө	19,373,860.89	12,261,507.18
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	18,272,930,763.43	35,424,547,789.12
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	20,044,287,482.82	37,119,889,757.47
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	165,033,998.90	124,759,045.22
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	9,185,923.09	911,106.48

“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТ

2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	4,100,000.00	16,768,000.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	178,319,921.99	142,438,151.70
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	638,868,689.40	606,923,040.11
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	638,868,689.40	606,923,040.11
2.2	Өр төлбөрийн нийт дүн	817,188,611.39	749,361,191.81
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,821,344,502.78	1,821,344,502.78
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	11,195,450,723.35	11,150,810,461.72
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	6,976,191,040.00	24,169,491,363.84
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(765,887,394.70)	(771,117,762.68)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	19,227,098,871.43	36,370,528,565.66
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	20,044,287,482.82	37,119,889,757.47
		-	-

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/Төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	19,190,452,149.25	20,863,420,022.13
2	Борлуулалтын өртөг	16,716,009,615.29	18,316,298,834.47
3	Нийт ашиг(алдагдал)	2,474,442,533.96	2,547,121,187.66
4	Түрээсийн орлого	13,926,981.46	10,167,524.68
5	Хүүний орлого	26,407,839.96	23,966,857.26
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	178,330,531.08	230,058,804.80
9	Борлуулалт, маркетингийн зардал	1,725,000.00	47,060,877.19
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,975,085,998.82	2,365,577,100.70
11	Санхүүгийн зардал	15,306,966.35	14,866,801.65
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүнийолз (гарз)	38,441.18	(4,455.98)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(1,884,486.10)	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэнолз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	(223,290,598.59)	(289,315,332.77)
18	Татвар төлөхийн өмнөхшиг(алдагдал)	475,853,277.78	94,489,806.11
19	Орлогын татварын зардал	2,640,784.00	2,396,685.72
20	Татварын дараах ашиг (алдагдал)	473,212,493.78	92,093,120.39
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусадолз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	473,212,493.78	92,093,120.39

**"ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТ**

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

"Дулааны хоёр дугаар цахилгаан станц" ТӨХК

2017 оны 12 сарын 31
/ төгрөг/

(Аж ахуйн нэгжийн нэр)

АУДИТЛАГДСАН

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эзлийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12 сарын 31	1,821,344,502.78			11,195,450,723.4		6,976,191,040.0	(765,887,394.70)	8,031,648,148.08
2	Нягтлан бодох бүртгэлийн болдогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
3	Залруулсан үлдэгдэл								
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)								
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт								
7	Зарласан ногдол ашиг								
8	Дамин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
9	2016 оны 12 сарын 31	1,821,344,502.78	-	-	11,195,450,723.4	-	6,976,191,040.0	(765,887,394.70)	19,227,098,871.43
10	Өмчлөх бодох бүртгэлийн болдогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							(97,323,488.37)	(97,323,488.37)
11	Залруулсан үлдэгдэл								
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							92,093,120.39	92,093,120.39
13	Бусад дэлгэрэнгүй орлого								
14	Өмчид гарсан өөрчлөлт						17,193,300,323.8		17,193,300,323.84
15	Зарласан ногдол ашиг								
16	Дамин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				(44,640,261.6)				(44,640,261.63)
17	2017 оны 12 сарын 31	1,821,344,502.78	-	-	11,150,810,461.7	-	24,169,491,363.8	(771,117,762.68)	36,370,528,565.66

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөг/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,293,716,449.63	20,770,215,096.69
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	19,990,407,192.38	20,123,667,271.61
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	59,822,501.00	73,771,669.65
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	243,486,756.25	572,776,155.43
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	19,924,107,671.49	20,592,118,487.62
	Ажиллагчдад төлсөн	5,005,300,344.23	5,670,764,576.21
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,279,464,125.78	1,441,675,918.20
	Бараа материал худалданавахад төлсөн	1,419,755,341.88	1,522,603,580.70
	Ашиглалтын зардалд төлсөн	1,040,966,920.81	2,231,705,233.55
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,760,284,871.70	7,344,239,841.69
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	1,918,213,739.10	1,897,720,763.94
	Даатгалын төлбөрт төлсөн	4,622,629.00	11,958,568.00
	Бусад мөнгөн зарлага	495,499,698.99	471,450,005.33
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	369,608,778.14	178,096,609.07
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	26,407,839.96	23,966,857.26
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	26,407,839.96	23,966,857.26
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	269,665,859.00	172,245,333.00

**“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТ**

	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	269,665,859.00	172,245,333.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(243,258,019.04)	(148,278,475.74)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	45,820.06	8,570.60
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
	Бусад	45,820.06	8,570.60
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	52,549,981.02	160,456,288.67
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	18,712,621.02	18,492,538.67
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг	33,837,360.00	141,963,750.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(52,504,160.96)	(160,447,718.07)
4	Валютын ханшийн зөрүү	(7,378.88)	(13,026.58)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	73,839,219.26	(130,642,611.32)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	252,399,332.26	326,238,551.52
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	326,238,551.52	195,595,940.20


 АУДИТОР **СИ ЭСЭЙ АУДИТ ХХК** Д.ЧУЛУУНБАТ
 УЗМ03039 6203001

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Аудит хийгдсэн "Дулааны хоёрдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн 2017 оны зорилтот түвшингийн үзүүлэлтийн биелэлт

	Үзүүлэлтүүд	х.н	2017 он		Зөрүү		
			төлөвлөгөө	гүйцэтгэл	Хувь	Биетээр	
1	Боловсруулсан ЦЭХ	сая.квтц	151.6	151.2	99.7	-0.4	
2	ДХЦЭХ	биетээр	сая.квтц	22.1	20.4	92.4	-1.7
		Хувиар	хувь	14.6	13.5	92.7	-1.1
3	Эрчим хүч түгээлт Цахилгаан	сая.квтц	129.5	130.7	101.0	1.3	
	Дулаан	мян.Гкал	193.0	195.6	101.4	2.6	
4	Нийт орлого	сая.төг	19,895.9	21,127.6	106.2	1,231.7	
	Үүнээс: Цэвэр борлуулалт	сая.төг	19,725.5	20,863.3	105.8	1,137.8	
5	Нийт зардал	сая.төг	20,502.4	21,035.5	102.6	533.1	
	Үүнээс: Удирдлагын зардал	сая.төг	224.0	211.9	94.6	-12.0	
6	Ашиг / алдагдал /	сая.төг	-606.5	92.1	-15.2	698.6	
	Цэвэр ашиг / алдагдал /	сая.төг	-606.5	92.1	-15.2	698.6	
7	Борлуулалтын 1 төг-т ногдох зардал	төг	1.0	1.0	96.6	0.0	
8	Авлага	сая.төг	822.6	326.0	39.6	-496.6	
9	Өглөг	сая.төг	906.9	749.4	82.6	-157.5	
	Үүнээс: Богино хугацаат өглөг	сая.төг	300.0	142.4	47.5	-157.6	
10	ХО, ИЗ, ТЗБАХ-ний зардал	сая.төг	2,377.4	2,274.1	95.7	-103.3	
11	Жишмэл түлшний зарцуулалт ЦЭХ	гр/квтц	638.4	642.6	100.7	4.2	
	ДЭХ	кг/Гкал	204.2	203.2	99.5	-1.0	
12	Аваарь саатал	тоо	-	-			


 СИЭС АЙ АУДИТ ХХК
 АУДИТОР Д.ЧУЛУУНБАТ

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
 САНАЛ ДҮГНЭЛТ**